



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗАА/2022/47-ШТА-ГА

Улиастай сум 2022 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 7046-3783, Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Заяа
Утас: 92038288, Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
НЭГ.ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА / ЗАВХАН,НӨМРӨГ СУМ/.....	5-6
ХОЁР. СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГА /ЗАВХАН,НӨМРӨГ СУМ/.....	6-7
ГУРАВ.СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАРИЛГА /ЗАВХАН,ТҮДЭВТЭЙ СУМ/.....	8-9
ДӨРӨВ. СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГА /ЗАВХАН,ТҮДЭВТЭЙ СУМ/.....	9
ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА /ЗАВХАН,СОНГИНО СУМ/.....	9-11
ЗУРГАА. 320 ХҮҮХДИЙН СУРГУУЛЬ, СПОРТ ЗААЛНЫ БАРИЛГА /ЗАВХАН, СОНГИНО СУМ/.....	11-12
ДОЛОО. 320 ХҮҮХДИЙН СУРГУУЛЬ, СПОРТ ЗААЛНЫ БАРИЛГА /ЗАВХАН, ТЭЛМЭН СУМ/.....	12-13
НАЙМ. СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГА /ЗАВХАН,ИДЭР СУМ/	
ЕС. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР /ЗАВХАН,ИДЭР СУМ/	
АРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА /ЗАВХАН,АЛДАРХААН СУМ/	
АРВАН НЭГ. НИСЭХ БУУДЛЫН АВТО ЗАМЫН УУЛЗВАРААС АЛДАРХААН СУМЫН ТӨВ ХҮРТЭЛХ 6.7 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ	
АРВАН ХОЁР. СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ /ЗАВХАН,АЛДАРХААН СУМ/	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын амгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай” А/34 дүгээр тушаалаар баталсан сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: Орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн ГХБХБГ, аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компаниуд, ашиглагч байгууллагуудын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит,Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа,тодруулга болон судалгаа авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр,горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт,зөвлөмж боловсрууллаа.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Б.Дагвасүрэн нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, УАГ-ын Гуравдугаар газрын багтай хамтран 2022 оны 05 дугаар сарын 31-ээс эхлэн 2022 оны 06 дугаар сарын 30-ний хооронд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад 2022 оны 05 дугаар сарын 31-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ыг дуустал 14 хоногийн хугацаанд ҮАГ-ын Аудитын Гуравдугаар газрын ахлах аудитор Б.Батдэлгэр, гэрээт ажилтан И.Дөлгөөнтуул, Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, ахлах аудитор Г.Заяа нар удирдамжийн дагуу ажиллалаа.

Аудитын явцад удирдамжид тусгагдсан 12 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг газар дээр нь захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч байгууллагуудын төлөөллүүдийг байлцуулан шалгаж, зураг төсөвтэй тулган илэрсэн зөрчлийг фото зургаар баталгаажууллаа.

Нэг.Цэцэрлэгийн барилга / Завхан,Нөмрөг сум/

Аймгийн ИТХ-ын 2018 оны 31 дүгээр тогтоолоор Нөмрөг сумын сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны барилгыг тус сумын хүүхдийн цэцэрлэгт балансаас баланст шилжүүлсэн байна.

Сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны барилга нь 1976 онд баригдсан, цутгамал төмөр бетон суурьтай, дүнзэн ханатай, модон хучилттай, шувуун нуруун дээвэртэй 2 давхар барилга байсан бөгөөд аймгийн Засаг даргад эрх шилжүүлэлгүйгээр 2015 онд Боловсрол шинжлэх ухааны яамны сайдын багцын 250.0 сая төгрөгөөр их засвар хийсэн байна.

Барилгын дээврээс дусаал гоожиж 2 дугаар давхрын дам нуруу, модон бамбай илжирч муудсан, аймгийн МХГ-ын улсын байцаагчийн 2015 оны 07-07-027-83 тоот дүгнэлт гарсан байсан тул “Есөн харш” ХХК-ийн боловсруулсан зураг төсвийн дагуу “Ган шугам дулаан” ХХК их засвар хийжээ.





Илэрсэн асуудал:

- Их засварын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад “Ган шугам дулаан” ХХК нь шалны болон халаалтын засварын ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүйгээс шал нь гажиж хөдөлгөөнд орсон, барилгын дулаан алдагдах нөхцөл бүрдсэн байна.
- Захиалагч их засварын ажлыг зураг төсөвтэй нь тулган ашиглалтад хүлээж аваагүй, улсын комиссын акт, холбогдох баримтыг ашиглагч байгууллага болон аймгийн ЗДТГ-ын архивын тасагт хүлээлгэж өгөөгүй.
- Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.8-д “гүйцэтгэгч барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохирлыг хариуцах” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах хугацаа дууссан байна.

Аудитын зөвлөмж:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. Аймгийн ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр Нөмрөг сумын цэцэрлэгийн барилгын шал, халаалтын системд их засвар хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх;
2. Барилгын тухай хуульд тусгагдсан захиалагчийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, ажил сайжруулах хугацаатай үүргийг аймгийн ГХБХБГ-т өгч, биелэлтийг тооцох;

Хоёр. Соёлын төвийн барилга /Завхан,Нөмрөг сум/

Нөмрөг сумын соёлын төвийн барилгын ажлыг 1,155.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-26/2020 дугаартай гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Ар Си Ди” ХХК Завхан аймгийн Засаг даргатай байгуулсан байна.

2020-2021 онд 450.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, барилгын гүйцэтгэл 20 хувьтай байна.



Илэрсэн асуудал:

- Барилгын зарим баганын хазайлт БНБД 52-101-10, БД 52-105-10 зэрэг нормыг зөрчсөн, төмөр бетон каркасын 7 баганын бетоны нягтруулалт муу хийгдсэн, 1 дүгээр давхрын 3 дам нурууны бетоны том дүүргэгч ялгарсан, 1 дүгээр давхрын 10 баганын бат бэх хангагдаагүй зэрэг нь ШУТИС-ын БАС-ийн Оношлогоо, зураг, төсөл судалгааны "РЕКОНСТРАКШН" төвийн дүгнэлтээр баталгаажсан;
- 2 дугаар давхрын цутгамал бетоныг хийж гүйцэтгээгүй байхад санхүүжилт олгосон нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19-д “барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах, 38 дугаар зүйлийн 38.1.3-т “зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 40 дүгээр зүйлийн 40.1.1-т “барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих”, , Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.1-т “Захиалагчийн чиг үүрэгт ТАХ-ний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативийн баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл арга хэмжээ бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн;

Аудитын албан шаардлага:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. 1 дүгээр давхрын 10 баганыг хүчитгэх зураг төсвийг баталгаажуулж, хүчитгэлийн болон багана, дам нурууны бетоны нягтруулалтын ажлыг гүйцэтгүүлэн, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

Гурав.Сумын Засаг даргын Тамгын газрын барилга

/Завхан,Түдэвтэй сум/

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын барилгын ажлыг 1,195.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-43/2020 дугаартай гэрээг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Саран инж девелопмент” ХХК нь Завхан аймгийн Засаг даргатай байгуулж, 2021 оны 10 сарын 19-ны өдрийн 19/2021 дугаартай комиссын нэгдсэн дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээлгэж өгсөн байна.



Илэрсэн асуудал:

Гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсвөөс дараах ажлуудыг өөрчилсөн, гүйцэтгэлийн зураг төсөвт өөрчлөлтийг оруулж хянуулаагүй, төсвийн зөрүүг тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн авсан байна.

- 442.7 м2 талбайтай гадна ханыг 360 мм-ийн зузаантай царууц хөнгөн блокон өрлөг, 100 мм-ийн зузаантай полистрол хөөсөнцөр дулаалга, 120 мм-ийн зузаантай гадна өнгөлгөөний тоосгон өрлөгөөр гүйцэтгэх байсныг 150 мм-ийн зузаантай хөөсөнцөр дулаалга, шавардлага, эмульс болгон өөрчилсөн;
- Үүдний хонгилын 124.2 м2 талбайтай шалыг чулуун хавтангаар өнгөлөх байсныг плита болгон өөрчилсөн;
- Цоколын хэсгийн агааржуулалтын цонхийг гаргаагүй битүүлсэн;
- Гадна талд модон самбартай ганжуулсан шилэн хаалга хийх байсныг төмөр рамтай түүхий шилэн хаалга болгон өөрчилсөн;

Аудитын акт:

1. Батлагдсан зураг төсвөөс өөрчилсөн ажлуудын төсвийн зөрүүг тооцон 10.95 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Дөрөв. Соёлын төвийн барилга /Завхан,Түдэвтэй сум/

Түдэвтэй сумын соёлын төвийн барилгын ажлыг 1,198.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-27/2020 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Этүгэн жим” ХХК Завхан аймгийн Засаг даргатай байгуулсан байна.

2020-2021 онд 450.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, барилгын гүйцэтгэл 20 хувьтай байна.



Илэрсэн асуудал:

- Барилгын цутгамал төмөр бетон шатны гүйцэтгэлийн ажлыг барилгын зургийн дагуу хийж гүйцэтгээгүй, Цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНБД 52-02-05, Ачаалал ба үйлчлэл БНБД 20-04-17, Бетон ба төмөр бетон бүтээц ерөнхий журам БНБД 52-01-10 зэрэг барилгын нормыг тус тус зөрчжээ.


Аудитын албан шаардлага:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. Барилгын цутгамал төмөр бетон шатны ажлыг буулган, барилгын зураг, норм дүрмийн дагуу дахин цутгах үүргийг албан шаардлагаар хүргүүлсэн.

Тав. Эрүүл мэндийн төвийн барилга /Завхан, Сонгино сум/

Сонгино сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 1,342.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-25/2018 дугаартай гэрээг 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдөр “Саран инж девелопмент” ХХК Завхан аймгийн Засаг даргатай байгуулан, барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 53/2019 дугаар комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулсан байна.



Илэрсэн асуудал, аудитын шийдэл:

1. Гүйцэтгэгч компанид уурын зуухны барилгын ажлын 162.3 сая төгрөгийн, гадна тохижилтын зүлэгжүүлэх ажлын 5.2 сая төгрөгийн, магадалшгүй ажлын 21.3 сая төгрөгийн, нийт 188.8 сая төгрөгийн санхүүжилтийг хийж гүйцэтгээгүй ажилд үндэслэлгүйгээр олгосон.
2. Барилгын эргэн тойрны явган хүний зам, хаяавч үйрч бутарсан, бохир нь өмхий үнэртэж, зэргэлдээх өрөөнүүдийн ханын доод хэсгийн замаск, эмульс ховхорсон, бороо орсон үед, дээврээс төрөх өрөө рүү дусаал дусдаг, үүдний дээд шилний завсараар бороо ороход байнга ус гоождог, өвлийн улиралд өвчтөнүүдийн өрөө халдаггүй, дулаан алдалт ихтэй байдаг, агааржуулалтын хоолой салхилах үед маш их дуугардаг, шороо тоос их ордог, ажилладаггүй, халуун усанд холбогдоогүй, угаалгын өрөөний таазны эмульс, замаска ховхорсон, төрөх өрөөний бохирын шугам задарч, 1-р давхарын өрөөний хана, таазны эмульс, замаска ховхорсон, чийрэгжүүлэлтийн өрөө, шатны хэсгийн хана нь цуурсан, зарим өрөө, коридориудын гэрэл шатсан, хог хадгалах байр болон эмийн сангийн агуулахын өрөөнүүд цахилгааны эх үүсвэргүй, эхчүүдийн амрах байр, үдэлтийн өрөөний үүдэн хэсгээр тоос шороо орж ирдэг завсаруудтай, цонхнууд хөлөрч, цантдаг, цонхны тавиур хэсгийн өргөн нь хэт нарийхан, барилгын гадна талын авто машины зогсоолыг хийгээгүй, гадна фасад халтартсан байна.

Аудитын шийдэл:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. Хийж гүйцэтгээгүй ажилд илүү олгосон 188.8 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
2. Дутуу болон чанаргүй хийгдсэн гадна зам талбайн тохижилт, бохирын шугам, дээвэр, агааржуулалтын систем, гадна цахилгаан, дотор болон гадна заслын ажлуудыг гүйцэтгэгчээр хийлгэн, биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх зэрэг үүргийг албан шаардлагыг хүргүүлээ.

Зургаа. 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга /Завхан, Сонгино сум/

Сонгино сумын сургууль, спорт заалны барилгын ажлыг 3,799.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-30/2020 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Харганат” ХХК Завхан аймгийн Засаг даргатай байгуулсан байна.

2020-2021 онд 1,753.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, барилгын гүйцэтгэл 40 хувьтай байна.



Илэрсэн асуудал:

- 2 дугаар давхрын цонхнуудын 2 талын ханыг тоосгон өрлөгийг гүйцэтгээгүй, хөнгөн блокоор өрсөн
- Багана, дам нурууны бетоны хийц ялгарсан

- Дам нуруунаас цахилгааны утас сүвлэсэн
- Хамар ханын тоосгоны ерөлтийг бэхлээгүй

Аудитын зөвлөмж:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. Гүйцэтгэгч компаниар илэрсэн зөрчлийг арилгуулах, захиалагчид барилгын бетон хийцийн бат бөх чанарыг шалгах үүрэг өгч, хэрэгжүүлэх

Долоо. 320 хүүхдийн сургууль, спорт заалны барилга /Завхан, Тэлмэн сум/

Тэлмэн сумын сургууль, спорт заалны барилгын ажлыг 3,795.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-25/2020 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Тэнгэрийн тэмдэг” ХХК Завхан аймгийн Засаг даргатай байгуулсан байна.

2020-2021 онд 1,625.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон, барилгын гүйцэтгэл 40 хувьтай байна.



Илэрсэн асуудал:

- Тэлмэн сумын сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгч “Тэнгэрийн тэмдэг” ХХК нь барилгын цутгамал төмөр бетоны 2 дугаар давхрын ажлыг гүйцэтгэхдээ Цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНбД 52-02-05, Ачаалал ба үйлчлэл БНбД 20-04-17, Бетон ба төмөр бетон бүтээц ерөнхий журам БНбД 52-01-10-д заасан цутгалт, арчилгааны технологийн нормыг зөрчсөн;

- Дотор хамар ханыг 120 мм-ийн тоосгон ханаар хийхээр байсныг хөнгөн болокон хана болгож өөрчилсөн;
- Дээврийн ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй;
- Спорт заалны цутгамал төмөр бетон баганыг алдаатай цутгасан;
- Өрлөгийн ялуунуудын суулт шаардлага хангаагүй;

Аудитын албан шаардлага:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. Гүйцэтгэгч болон зураг төсөв зохиогч компаниар илэрсэн зөрчлийг арилгуулан, биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх албан шаардлагыг хүргүүлээ.

Найм. Соёлын төвийн барилга /Завхан,Идэр сум/

Идэр сумын соёлын төвийн барилгын ажлыг 1,127.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №ТӨБЗГ-2019/ХИ.2.1.55 дугаартай гэрээг 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдөр “Зуурмаг” ХХК БСШУСЯ-ны төрийн нарийн бичгийн даргатай байгуулсан байна. 2021 оны 08 дугаар сарын 17-нд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан төсөвт өртгийг 1,699.8 сая төгрөг, дуусгах хугацааг 2022 оны 06 дугаар сарын 01 болгон сунгасан байна. Ковидын нөхцөл байдал, барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалан уг барилга гэрээний хугацаандаа ашиглалтад ороогүй байна.



Зуурмаг ХХК нь батлагдсан зураг төсвийн дагуу барилгын ажлыг 80 хувьтай гүйцэтгэж байгаа бөгөөд соёлын төвийн заалны өрөөний хана, таазанд бүрэн дуу тусгаарлагч хавтан хийхээр төлөвлөгдсөн байна.

Ес. Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Завхан,Идэр сум/

Идэр сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг аймгийн ОНХС-ийн 86.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр №БУ-35/2019/ дугаартай гэрээг 2019 оны 07 дугаар сарын 04-ны өдөр “Хэрмээдэй” ХХК Завхан аймгийн Засаг даргатай байгуулж, 2019 оны 11 сарын 21-ны өдрийн 50/2019 дугаартай комиссын нэгдсэн дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээлгэж өгсөн байна.



Илэрсэн асуудал:

Их засварын ажил нь батлагдсан зураг төсөвгүйгээр хийгдсэн, Хэрмээдэй ХХК-ийн боловсруулсан хянагдаагүй зураг төсөвтэй ажлыг аймгийн ГХБХБГ-аас ашиглалтад хүлээж авсан, их засварын ажлыг хүлээж авахдаа гүйцэтгэлийг ажлын тоо хэмжээтэй тулгаагүй, цахилгааны болон цэвэр, бохир усны засварын ажлын үр дүнг шалгаагүй байна.

Аудитаар газар дээр нь очиж шалгахад цахилгааны засвар хийгдсэн боловч гэрэл шатдаг үндсэн шалтгаан арилаагүй, цэвэр, бохир усны засвар хийсэн боловч одоо болтол ашиглаагүй, үр дүн нь гараагүй байна.

Их засварын ажлын тоо хэмжээтэй тулгахад дараах ажлуудыг дутуу гүйцэтгэсэн байна.

1. 2 м2 хүртэл талбайтай 13 ш хуванцар рамтай цонх угсрах
2. 280 м2 талбайтай төмөр дээврийг 2 удаа багсаар будах
3. 280 м2 талбайтай гадна ханыг фасадны будгаар будах
4. 18 ш хамгаалагдсан патрон гэрэлтүүлэгч угсрах
5. Аваарын гэрэлтүүлэг угсрах
6. 301 м нэг ба олон судастай дараагийн утас бүрийг сүвлэх
7. 810 м нэг ба олон судастай 1-р утас сүвлэх
8. 548 м нэг ба олон судастай 1-р утас сүвлэх
9. Д 20-32 мм2 987 м хуванцар хоолой угсрах
10. 44 м төмөр хайрцаг тавих
11. Газардуулагчтай холбоотой 6 ажил

12. Халуун хүйтэн устай ширмэн паалантай тосгуур угсрах
13. Шүршүүрийн дүш угсрах

Аудитын албан шаардлага:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авах, бүртгэлд тусгах явцад тавих хяналтыг сайжруулах үүргийг аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн, биелэлтийг тооцох;
2. Их засварын ажлын зураг төсвийг хянан, гүйцэтгэгч компаниар зураг төсвөөс дутуу хийгдсэн ажлуудыг хийлгэн, биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх зэрэг үүргийг албан шаардлагыг хүргүүлээ.

Арав. Эрүүл мэндийн төвийн барилга /Завхан,Алдархаан сум/

Алдархаан сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилга барих № ЭМЯ/XVII.1.52/ дугаартай гэрээг Арь констракшн ХХК 2019 оны 08 дугаар 06-ны өдөр 1,058.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргатай байгуулж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 48/2020 дугаартай комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулсан байна.



Илэрсэн асуудал:

- Батлагдсан зураг төсвөөс 4 босоо душ хийх ажлыг хийгээгүй, нэмэлтээр 5 усан теннийг их эмчийн өрөө, 4 үзлэгийн өрөөнд суурилуулсан;

- Их эмчийн өрөө, 4 үзлэгийн өрөөнд халаалтын радиатор байхгүйгээр, мэс заслын болон тарианы өрөөнд тус бүр 1 халаалтын радиатор суурилуулахаар зураг төсөвт тусгагдсан, зураг төсвийг магадлалаар баталгаажуулсан байхад бодит байдалд уг өрөөнүүдэд дулаан алдалт бий болсон;
- Коридорын шалны хулдаасны ам дарагчийг хийгээгүй;
- Барилгын дээврээс ус алдан 26 дугаартай ариун цэврийн өрөөний тааз шарласан, 23,25,26,34,35 дугаартай өрөөнүүдийн суултуурын татуурга, гол тогооны өрөөний 6 тосгуурын крант зэргийн хэвийн ажиллагаа алдагдсан;
- Барилга ашиглалтад хүлээн авах улсын комиссоос өгсөн үүрэг даалгавраас утааны мэдрэгчийг жигд ажиллуулах, дуут дохио ажиллуулах, агшин зуурын халаагч байрласан разеткуудад ус чийгний хамгаалагчтай хайрцаг, 220 вт-ын дифференциал автоматын хамт суурилуулах зэрэг 2 үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
- Барилгын магадлагдсан төсвийг ашиглагч байгууллага, аймгийн архивын тасагт хүлээлгэж өгөөгүй;


Аудитын шийдэл:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

1. 4 босоо душны төсөвлөгдсөн үнээс 5 усан теннийн үнийг хасан зөрүү 2.1 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон.
2. Зураг төсөл зохиогч “Бес онцгой дизайн” ХХК-д барилгын дулааны тооцоог дахин хийлгэх, 7 өрөөний дулаан алдагдлыг хэмжин, дулаан алдагдлын шалтгааныг арилгах үүргийг хүргүүлэн хэрэгжүүлэх;
3. Гүйцэтгэгч Арь констракшн ХХК -аар дутуу хийгдсэн болон сантехникийн үйл ажиллагааг жигдрүүлэхтэй холбоотой ажлуудыг гүйцээлгэн, биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх зэрэг үүргийг албан шаардлагыг хүргүүллээ.

Арван нэг. Нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай авто зам

Донойн нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай автозамын ажил гүйцэтгэх БУ-23/2019 дугаартай гэрээг 2019 оны 06 дугаар 20-ны өдөр “Тэргүүн саруул зам” ХХК 5,314.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Завхан аймгийн Засаг даргатай байгуулсан байна. 2019-2021 онд 4,931.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, замын гүйцэтгэл 90 хувьтай байна.



Илэрсэн асуудал:

- 2019 оны 07 сарын 23-ны өдөр иргэн Ш.Ишдоржтой захиалагчийн хяналт гүйцэтгэх, хөлсөөр ажиллах №2019/01 дугаартай гэрээг байгуулан захиалагчийн хяналтын зардалд 26.4 сая төгрөг олгосон нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д "зөвлөх үйлчилгээ" гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг, 37 дугаар зүйлийн 37.2-т "Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
- Аймгийн Засаг дарга нь Донойн нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай автозамын болон сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд баригдах 1.3 км замын ажлын хяналтын зардал 103.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн техник хяналтын зардалд төвлөрүүлэн, 76.9 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Аудитын шийдэл:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

- Захиалагчийн хяналтын зардлаас зарцуулаагүй 76.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
- Замын ажлыг ашиглалтад хүлээж авахдаа ажлын тоо хэмжээтэй гүйцэтгэлийг тулган шалгах, замын урт, өргөн, гүнийг хэмжих, зохиогчийн хяналтаар илэрсэн

зөрчлийг хэрхэн арилгасныг хянах, явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх байсныг бетоноор хийсний төсвийн зөрүүг тооцож гүйцэтгэлээс хасах зэрэг үүргийг албан шаардлагаар хүргүүлсэн.

Арван хоёр. Сумын төвийн шинэчлэл /Завхан,Алдархаан сум/

Алдархаан сумын төвийн шинэчлэлийн ажил гүйцэтгэх №БУ-29/2019 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр “Бурханхясаат” ХХК 4,885.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Завхан аймгийн Засаг даргатай байгуулан, 2019-2020 онд 4,272.5 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Ерөнхий гүйцэтгэгч “Бурхант Хясаат” ХХК нь дулаан цэвэр, бохир усны шугамын угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 50 м3-ийн цэвэрлэх байгууламж, усан сан, зуухны барилга тоног төхөөрөмжийн угсралт, цэцэрлэгт хүрээлэнгийн ажлуудыг “Тоска” ХХК, сумын төвийн доторхи авто замын ажлыг “Тэргүүн саруул” зам ХХК, зураг төсвийг “Сонголт Дизайн” ХХК тус тус гүйцэтгэхээр ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Гүйцэтгэгч компани сумын төвийн шинэчлэлтийн ажлыг 2020 онд ашиглалтад оруулаагүйн улмаас үлдэгдэл 612.0 сая төгрөг улсын төсөвт татагдан, 2021 онд уг санхүүжилт батлагдаагүй тул ажил хийгдээгүй.

Сумын төвийн шинэчлэлийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр захиалагч, гүйцэтгэгч нар харилцан тохиролцож гэрээ байгуулсан бөгөөд гүйцэтгэл нь дараах бадалтай байна.


д/д	Хийгдэх ажлын нэр	Гэрээний дүн /сая төгрөг/	Ажлын тоо хэмжээ	Гүйцэтгэл
1	Усан сан, нөөцийн сав тоног төхөөрөмжийн ажил 50м3	201.5	137.7 м2 талбайтай Усан сангийн тоосгон барилга, 50 м3-ийн эзэлхүүнтэй 2 нөөц савтай	90 хувьтай
2	50 м3 ахуйн ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажил	392.2	36 м2 талбайтай цэвэрлэх байгууламжийн сендвичэн ханатай барилга, тоног төхөөрөмж	95 хувьтай
3	Халаалтын зуухны барилгын ажил	284.2	225 м2 талбайтай тоосгон барилга,	45 хувь

Орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

4	Цэцэрлэгт хүрээлэнгийн зам талбай ногоон байгууламжийн ажил	141.5	1771 ширхэг мод тарих, 60 м3 хайрган зам, 3232м2 явган хүний зам, талбай барих	55 хувьтай
5	Гадна дулааны шугамын ажил	1,103.8	3956 м	3756 м
6	Гадна ариутгах татуургын шугамын ажил	518.7	1890 м	2156 м
7	Гадна цэвэр усны шугам	161.0	1856 м	1759м
8	Замын ажил	1,360.0	1.3 км	90 хувьтай
9	Бусад зардал / Зураг, төсөв, магадлашгүй ажил, НӨАТ/	722.1		
Дүн		4,885.0		



Усан сангийн барилга



Цэвэрлэх байгууламж



Уурын зуухны барилга



Илэрсэн асуудал:

1. 2017 оноос эхлэн “Ган доной” ХХК нь Алдархаан сумын төсөвт байгууллагуудын гадна халаалтын шугамуудыг холбох ажлыг компанийн хөрөнгөөр хийж, нэгдсэн халаалтаар хангаж байсан боловч халаалтын барилга нь стандартын шаардлага хангаагүй байсан байна. АЗДТГ-ын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэсээс 2019 оны 04 дүгээр сард сумын төвийн инженерийн байгууламж, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажлын даалгавар гаргахдаа “Ган доной” ХХК-ийн халаалтын шугам сүлжээ, халаалтын зуухыг ашиглахаар, айл өрхүүдийг нэмж халаахаар, 284.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй халаалтын тогооны барилгыг шинээр барихаар төлөвлөжээ. Гэтэл 2020 онд “Ган доной” ХХК нь халаалтын тогооны барилгадаа их засвар, шинэчлэлт хийн, сумын төвийн

шинэчлэлт төслийн хүрээнд баригдаж байгаа халаалтын тогооны барилгыг ашиглахгүй, үр ашиггүй зардал гаргасан гэсэн маргааныг үүсгэснээр уг барилгын ажил түр зогссон байна. Алдархаан сумын Засаг даргаас сумын төвийн шинэчлэлт төслийн хүрээнд баригдаж байгаа халаалтын тогооны барилгыг зураг төсвийн дагуу үргэлжлүүлэн барих албан хүсэлтийг 2022 оны 05 дугаар сарын 12-нд ирүүлснээр гүйцэтгэгч компани барилгын ажлыг үргэлжлүүлж байна. Ингэснээр “Ган доной” ХХК-аас сумын удирдлагын шийдвэрээр халаалтын бизнесийн үйл ажиллагааг зогсоосон гэж үзэн төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтад холбоход гарсан зардлыг сумын ЗДТГ-аас нэхэмжлэх эрсдлийг бий болгож байна. Аймгийн Засаг дарга, аймгийн ГХБХБГ-аас халаалтын зуухны барилгыг зураг төсвийн дагуу үргэлжүүлэн барих нэгдсэн шийдвэрийг гаргаагүй байна.

2. Захиалагч сумын төвийн шинэчлэл төслийн зургийн даалгавар боловсруулахдаа гадна цахилгааны техникийн нөхцөл аваагүйгээс шалтгаалан цэвэрлэх байгууламж, халаалтын тогоо, усан сангийн барилгуудын гадна цахилгааны ажил зураг төсөвт тусгагдаагүй орхигдсон байна. 2020 онд гадна цахилгааны техникийн нөхцөлийг аван, ажлын зураг төсвийг боловсруулан магадлалаар баталгаажуулахад 86.0 сая төгрөгийн төсөв шаардлагатай гэсэн тооцоолол гарсан. Энэ тооцооллыг сумын төвийн шинэчлэлийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгаагүй байна.
3. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн сумын төв доторх 1.3 км хатуу хучилттай замын 2 талаар 60 вт-ын нарны зайн гэрэлтүүлэгтэй байхаар ажлын тоо хэмжээг захиалагч боловсруулсан боловч зураг төсвийн “Ар си эс си” ХХК замын гэрэлтүүлгийн ажлыг тусгалгүй орхигдуулсныг хянаагүй байна.
4. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн сумын төв доторх 1.3 км хатуу хучилттай замын суурийн ажлын 20.0 см хайрган дэвсгэр байгуулах, цементээр бэхжүүлсэн 20 см суурь байгуулах ажлын хяналт хангалтгүй, ус зайлуулах байгууламжийн шуудууг 15 см-ийн чулуун өрлөг хийж бэхлэх ажлыг 6-11.0 см-ийн зузаантай гүйцэтгэсэн, явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх байсныг бетоноор хийсний төсвийн зөрүүг тооцож, гүйцэтгэлийг баталгаажуулаагүй байна.

Аудитын албан шаардлага:

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалд:

- Сумын төвийн шинэчлэлт төслийн хүрээнд баригдаж байгаа халаалтын тогооны барилгыг зураг төсвийн дагуу барих эсэх асуудлыг хуулийн хүрээнд эцэслэн шийдвэрлэх;
- Цэвэрлэх байгууламж, халаалтын тогоо, усан сангийн барилгуудын гадна цахилгааны ажлын хөрөнгийг асуудлыг магадлашгүй ажлаас санхүүжүүлэх,

зөрүү 32.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-аас шийдвэрлэн, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах;

- Зураг төсвийг батлахдаа зургийн даалгавар, ажлын тоо хэмжээг хянаж хэвших;
- Замын ажлыг ашиглалтад хүлээж авахдаа ажлын тоо хэмжээтэй гүйцэтгэлийг тулган шалгах, замын урт, өргөн, гүнийг хэмжих, зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг хэрхэн арилгасныг хянах, явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх байсныг бетоноор хийсний төсвийн зөрүүг тооцож гүйцэтгэлээс хасах зэрэг үүргийг албан шаардлагаар хүргүүлсэн.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА